БАЯН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2022 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.01.04 Мааньт

**Эрхэм зорилго:** Монгол Улсын Хуулийг дээдлэн сахиж иргэдийнхээ эрх ашиг,сонирхолыг хамгаалан, Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын үр нөлөө, чанар, хүртээмжийг дээшлүүлснээр нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж, орон нутгаа хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Найм дахь удаагийн ИТХ-ын сонгуулиар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 3 тойргийн 21 Төлөөлөгч, ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

**Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа:** 2022 онд сумын ИТХ-ын ээлжит 7-11 дугаар хуралдаан, ИТХ-ын ээлжит бус 2 удаа хуралдсан. Хурлын дундаж ирц 67.5 хувьтай байна. Нийт 38 асуудал хэлэлцэж 120 заалт бүхий 40 тогтоол шийдвэр баталж хурлын бодлого шийдвэрийн хэрэгжилт, ажил эрчимжүүлэх эрх зүйн зарим зохицуулалтыг боловсронгуй болгох, эдийн засаг, төсөв санхүү, үйлдвэрлэл үйлчилгээ, орон нутгийн өмч,байгаль орчин, газар, нийгмийн салбарын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.






Хурлын байгууллагад ирсэн бичиг 78, явуулсан бичиг 29, өргөдөл хүсэлт 0, ирсэнийг хугацаанд нь барагдуулсан. 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр аймаг, сумын ИТХ-ын "Төлөөлөгчийн өдөр"-ийг "Малчдын зөвөлгөөн"-тэй хамтатган зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, ИТХ-ын дарга Л.Батсуурь, Засаг дарга М.Мөнх-Эрдэнэ, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Ж.Баттөгс, сумын ИТХ-ын Төлөөлөгчид оролцсон.






Баян сумын ИТХ-ын ажлын алба болон Засаг даргын тамгын газраас 2022 оны 10-р сарын 21-ний өдөр Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж Аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Ж.Баттөгс, Баян сумын ИТХ-ын дарга Л.Батсуурь, Засаг дарга М.Мөнх-Эрдэнэ, үе үеийн ИТХ-ын дарга нар болон Төлөөлөгчид оролцсон.

Мөн хүндэтгэлийн арга хэмжээний үеэр шагнал гардуулах ёслолын ажиллагаа болсон. Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар Л.Батсуурь, Г.Энхтайван, Т.Шагдар, Ц.Оюунбилэг, Төв аймгийн ИТХ-ын "Хүндэт тэмдэг"-ээр Д.Өлзийхишиг, Г.Долгорлхам, Төв аймгийн ИТХ-ын "Хүндэт жуух бичиг"-ээр А.Ганболд, Х.Нямаахүү, Ж.Долгор, Төв аймгийн, Засаг даргын "Хүндэт жуух бичиг"-ээр Д.Нямхүү, Монголын нутгийн өөрөө удирдах байгууллагын "Зөвлөх мэргэжилтэн тэмдэг"-ээр Д.Батзэвгэ, Н.Чулуунжав, С.Жалбацант, Монголын нутгийн удирдлагын Холбооны "Соёмбо тэмдэг"-ээр Ж.Бат-Адъяа, "Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан цол тэмдэг"-ээр Д.Алтангэрэл, "Хүндэт өргөмжлөл"-өөр М.Наранцэцэг, Т.Цогсүрэн нар тус тус шагнагдсан.










Аймгийн төр, захиргааны болон нутгийн удирдлагын ахмад зүтгэлтэн ИТХ-ын ажлын албаны ахмад ажилтан М.Эрдэнэдалай гуай Баян сумын ИТХ-Төлөөлөгчдөд сургалт хийсэн. Сургалтын сэдэв: 1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2. Төсвийн тухай хууль, 3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах үед анхаарах асуудал, 4. Цаг үеийн нөхцөл байдлын талаар сургалт зохион байгуулсан.










**Цагаатгах үйл ажиллагаа:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн 218 тоот албан бичгийн дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг дараах байдлаар тэмдэглэн өнгөрүүлэв. Манай суманд албан ёсны бүртгэлтэй хэлмэгдэгсдийн Жадамбын-Арилд, Сүхбаатарын Цэдэвдорж, н.Дэлгэр иргэд байна. Эдгээр хүмүүст тус өдрийг тохилдуулан хүндэтгэл үзүүлэв. Мөн “Хэлмэгдүүлэлт ба сургамж” эссэ бичлэгийн уралдааны удирдамж батлуулан зохион байгуулав. 1-р байранд ЕБС-ийн багш Э.Хулан, 2-р байранд Төмөр замын эмч Б.Долгормаа, 3-р байранд ЗДТГ-ын мэргэжилтэн Ш.Одгэрэл нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Бамбар-Эрдэнэ хийдийн лам Бархас ламтай утсаар холбогдож буяны ном хуруулсан.









Улаан загалмайн нийгэмлэгт 455000 төгрөгийн хандив тусламж үзүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулах шатар сонирхогчдын Сумын аварга шалгаруулах 2022 оны анхан шатны шатрын тэмцээнийг удирдамж гарган 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр сумын Соёлын төвд зохион байгуулсан. Тус тэмцээнд эрэгтэй төрөлд 5 шатарчин, эмэгтэй төрөлд 3 шатарчин оролцож тойрог хэлбэрээр тоглолт явагдсан. Эрэгтэй шатрын төрөлд ШШГЕГазрын харьяа нээлттэй, хаалттай хорих 415 дугаар ангийн албан хаагч Н.Оюунбаатар, дэд байранд ахмад настан Д.Баяртнасан. Эмэгтэй төрөлд Цавчир 3-р багийн иргэн М.Сосор 1-р байр, дэд байранд ИТХ-ын дарга Л.Батсуурь нар шалгарав. Тэмцээний шагналын сан 1-р байранд тус бүр УИХ-ын дарга Г.Занданшатарын гарын үсэгтэй Талархал, Өргөмжлөл, 30.000 төгрөг, дэд байранд Өргөмжлөл, 20.000 төгрөгийн хамтаар шагнасан.





**Гэмт хэргээс урьчдилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл:** Сумын Гэмт эргээс урдьчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр салбар зөвлөлийн 17 гишүүнээс 15 гишүүн ирж, хурлын ирц 82%-тай хуралдсан. ГХУСАЗСЗ-ийн 2022 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Тус төлөвлөгөө нь 2 арга хэмжээний 9 заалт бүхий төлөвлөгөө байна. Төлөвлөгөөнд тусгагдсанаар 04 дүгээр сард ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөө батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу 05 дугаар сард аймгийн Цагдаагийн газраас х/ч н.Нарантуяа, а/д н.Ундармаа нар ард иргэд болон ЕБС-ийн 6-9 ангийн сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээлэл хийсэн. Мөн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Малчдын Зөволгөөн зохион байгуулсан. Тус зөвлөгөөнөөр аймгийн Цагдаагийн газраас “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар малчдад сургалт орж, гарын авлага тараасан. Сумын хамтарсан багтай хамтран гэр бүлийн

хүчирхийлэлийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрлийн арга хэмжээ зохион байгуулж тайланг аймгийн ГХУСАЗСЗөвлөлд хүргүүлсэн. Төсөвт байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.















Сумын хэмжээнд Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийн судалгаа, Ойр орчимдоо түгшүүр төрүүлдэг архичдын судалгаа, Гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй иргэдийн судалгаа өөр бусад судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан бүрдүүлсэн. Аж ахуй нэгж албан байгуулагуудад Архигүй үлгэрлье аяныг зохион байгуулсан. Намайг алгас аяны хүрээнд зурагт хуудас хийж албан байгууллага, худалдаа үйлчилгээний газруудаар хүргүүлсэн.












**Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах салбар зөвлөл:** Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар зөвлөлөөс 2022 онд 2 удаа ЗДТГ-ын хяналт шалгалтын ажлын хэсэгтэй хамтран шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад үнийн хэт хөөрөгдөлтэй худалдааны байгууллага байгаагүй. Бүтээгдэхүүн дээрх үнийг кассын машинтай харьцуулж үзсэн. Хяналт шалгалтын тоо нь багассан учир нь ковид 19 цар тахалтай хобоотойгоор 2021-2022 оны хяналтын тоо багассан. 2022 онд иргэнээс ямар нэгэн гомдол ирээгүй. Худалдаа үйлчилгээний газруудаас 5 удаа өргөн хэрэглээний барааны судалгаа авч хууль зүйн хэлтэст хүргүүлсэн.










ХЯНАСАН:

ИТХ-ЫН ДАРГА Л.БАТСУУРЬ

ТАЙЛАН БИЧСЭН:

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.УРАНГОО